

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.03.29

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр				
1	Байгууллагын албан хаагчдын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил, сараар төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны төлөвлөлт, ажлын хариуцлага, цаг ашиглалт, үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна.	Байгууллагын албан хаагчдын үр дүнгийн гэрээ болон үйл ажиллагааны төлөвлөгөөг ГБХЗХГ-ын даргаар батлуулж, өдөр тутмын болон 7хоногийн үйл ажиллагааныхаа төлөвлөлтийг e-office программ дээр төлөвлөн, тогтмол ашиглаж байна.	100%
2	Байгууллагын үйл ажиллагааны тайлан гаргах хуваарийг боловсруулах	Байгууллагын үйл ажиллагааны тайлангуудыг хуваарийн дагуу хуулийн хугацаанд нь холбогдох дээд шатны байгууллагад хүргэсэн байна.	Байгууллагын үйл ажиллагааны тайлан гаргах хуваарийг боловсруулан батлуулж, тайланг цаг тухайд нь засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-т хүргүүлж байна.	100%

3	2016 оны үйл ажиллагаанд ХШҮ-ний багаас өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах	ХШҮ-ний багаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	2016 оны байгууллагын үйл ажиллагаанд ХШҮ-ний багаас өгсөн үнэлгээ, зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөөг ГБХЗХГ-ын даргаар батлуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
4	Байгууллагын нийт алба хаагчдын нийгмийн байдлын судалгааг гаргаж, ХНХ-ын яаманд хүргүүлэх	Нийгмийн салбарын алба хаагсдын амьдралын баталгааг мэдэх, тэдний цаашдын амьдралд дэмжлэг үзүүлэх нөхцөлийг судалсан байна.	Аймгийн ГБХЗХГ-ийн албан хаагчдын нийгмийн байдлын судалгааг нэгтгэж, 2017 оны 01 дүгээр сарын 20-нд ХНХ-ын яаманд хүргүүлсэн.	100%
5	Байгууллагын алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх	Ажил үүргийн хуваарь тодорхой болж, өөрийн ажилдаа хариуцлагатай, үр бүтээлтэй хандана. Сул орон тоо нөхөгдөнө.	Байгууллагын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, сул орон тооны захиалгыг төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр бэлтгээд байна.	90%
6	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаар болон ГБХЗХГ-ын албан хаагчдын үйл ажиллагааны талаар, байгууллага, хувь хүний	Байгууллагын эрхлэх хүрээний асуудалтай холбогдсон санал гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэн ажиллана.	www.7059106.mn сайтад 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хүүхдийн мөсөн гулгуурын талбайтай холбоотой 1 гомдол ирснийг манай байгууллагад шилжүүлсний дагуу хүүхэд хамгааллын мэргэжилтэн Б.Цэцэг асуудлыг шалгаж	100%

	амаар, бичгээр, цахим хэлбэрээр гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийн дагуу шуурхай арга хэмжээ авч, санал гомдлын хариуг www.106.mn -д байршуулах		тодруулан, эцэг эхэд хариу мэдэгдэж, гомдлыг шийдвэрлэлээ.	
7	Байгууллагын стратегийг шинэчлэн боловсруулах	Ажлын чиг үүрэг тодорхой болж ажлын давхардал болон хийдэл үүсэхгүй байх	Байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
8	Салбар дундын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсролын чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулах	Салбар дундын байгууллагын уялдаа холбоо сайжирсан байна.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар үүрэгч хүлээгчид, салбар дундын байгууллагуудтай тогтмол хамтран ажилладаг бөгөөд албан ёсоор хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллахаар гэрээний төслийг боловсруулаад байна.	90%
9	Байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд аудитын шалгалт хийлгэж, зөрчилгүй ажиллах	Санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг үйл ажиллагаандаа бүрэн тусгаж ажилласан байх	Байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд аудитийн шалгалт хийлгэж, зөрчилгүй шалгагдсан бөгөөд аудитын дүгнэлттэй холбоотой зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
10	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлж,	Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана.	ГБХЗХГ-ын дарга Ц.Ганзориг, ахлах мэргэжилтэн Ц.Энхбилгүүн нар 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр ХАСХОМ-ийг авлигатай тэмцэх газарт мэдүүлэн, нийтийн албанд хувийн ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй	100%

	нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг бүрэн хянуулж, ашиг сонирхлын зөрчилгүй томилгоог хэвшүүлэх		ажиллаж байна.	
11	Гэр бүл, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн дунд зохион байгуулах сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтуудыг зохион байгуулах	Баг, сургуулийн нийгмийн ажилтнууд, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх чадвар нэмэгдэж, анхан шатны нэгж дээр кейстэй ажиллаж сурсан байна.	Аймгийн ГБХЗХГ-аас санаачлан “Дэлхийн зөн” орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран сургуулийн нийгмийн ажилтнууд, ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд, сургуулийн СОУЗ-ийн гишүүдэд “Оролцоод хөгжье” сэдэвт сургалтыг 2017 оны 01 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн О.Сэлэнгэ зохион байгууллаа.	100%
12	Хүүхэд харах үйлчилгээний үйл явцад тогтмол хяналт шалгалт явуулж, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Хүүхэд харах үйлчилгээний стандарт хангагдсан байна.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан "Хүүхэд харах үйлчилгээнд хяналт, шалгалт хийх ажлын удирдамж"-ийн дагуу Дундговь аймгийн Сайнцагаан суманд "ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭ" эрхэлж буй 1 иргэний үйл ажиллагаатай танилцаж, үйлчилгээний байрны гадна, дотно орчин, хүүхэд харах үйлчилгээний үндсэн болон нийтлэг шаардлага, хоол, хүнс, эрүүл ахуй, эрүүл мэнд, хүүхэдтэй харилцах, харилцаа хандлага, анхан шатны санхүүгийн баримт зэрэгт хяналт, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн	100%

			ажиллалаа. Мөн аймгийн БСУГ-тай хамтран Сайнцагаан сумын 7 цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.	
13	“Хүүхдийн дуу хоолой” аймгийн хүүхдийн 11-р чуулганыг зохион байгуулж, сум орон нутгийн хөгжилд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх	Хүүхдүүд өөрсдийн өмнө тулгамдсан асуудлаа дэвшүүлж, үүрэг хүлээгч нар тэдний дуу хоолойг сонсон хэрэгжүүлсэн байна	Хүүхдийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэх, өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцож, хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах, бүлэг хамт олноор дамжуулан боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудал, үе тэнгийн хүчирхийлэл, дарамтыг бууруулах зорилготой “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” аймгийн хүүхдийн 11-р чуулганыг “Би том гартай ч хүчирхийлэгч биш” уриатайгаар 2017 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газар, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн дундговь ОНХХ, “Оюуны гэгээ” сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгтэй хамтран зохион байгууллаа. Чуулганд оролцсон төлөөлөгч хүүхдүүд “Дотуур байр миний 2 дахь гэр”, “Хүүхдэд ээлтэй багш”, “Цахим орчны зөв зохистой хэрэглээ”, “Сургууль дахь найз нөхдийн нөхөрсөг харилцаа”, “Хөгжих орчин ба чөлөөт цаг” гэсэн 5 бүлгийн хүрээнд хэлэлцэж, “Оноо өгөх” аргачлалыг ашиглан тулгамдаж буй асуудлаа гарган, “Жүжиг”, “Зураг”, “Дуу”, “Шүлэг”-ийн	100%

			аргаар шийдвэр гаргах түвшнийхэнд дуу хоолойгоо хүргэлээ. Мөн төлөөлөгч хүүхдүүд гаргасан шийдвэрээ хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн дарга, бусад салбар дундын байгууллагын удирдлагуудад бичгээр хүлээлгэн өглөө.	
14	“Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” хүүхдээ сонсох өдөртэй болох	Үйл ажиллагааны төлөвлөгөө болосвруулж, хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.	Гэр бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газар, Дэлхийн Зөн Дундговь орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран хүүхдүүд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах үнэлэлт өгөхөд оролцох, хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах, тэдний нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах зорилготойгоор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор “Хүүхдийн дуу хоолой ба үр нөлөө” нэртэй хүүхдээ сонсох өдөртэй боллоо. Тус ажлын хүрээнд ажлын хэсгийн гишүүдийг чадваржуулах 2 өдрийн сургалтыг зохион байгуулав. Сургалтанд хамрагдсан ажлын хэсгийн гишүүдийг 12 баг болгон хувааж, чиглэл чиглэлээр асуудлаа танилцуулж ажиллахаар боллоо.	90%

15	Хүүхдийн тусламжийн утас 108-ийг сум, орон нутагт сурталчлан таниулж, 108-д ирсэн санал хүсэлтийг хэрэгжүүлж, эргэх холбоог сайжруулан ажиллах	Хүүхдийн тусламжийн 108 утасны талаар олон нийт мэдээлэлтэй болж эргэх холбоо сайжирсан байна.	Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2017 оны эхний улирлын байдлаар 3 зөрчлийн мэдээллэл ирснийг хүлээн авч, холбогдох харьяа газарт шилжүүлэн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.	100%
16	Хүүхдийн статистик үзүүлэлтийг цуглуулж, мэдээллийн сан үүсгэж, дүн шинжилгээ хийх	Мэдээллийн сан үүсгэсэн байна.	126 шалгуур үзүүлэлтийн дагуу 2016 оны хүүхдийн статистик үзүүлэлтийг нэгтгэж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-т хүргүүлсэн.	100%
17	Аймаг, сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	Арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласнаар хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий сумын түвшинд ажиллах салбар дундын хамтарсан багийг чадваржуулах "Кейстэй ажиллах арга зүй" сургалтыг Дэлхийн зөн Дундговь орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Боловсрол соёл урлагийн газартай хамтран Дундговь аймгийн 19 сургууль, МСҮТ, Сайнцагаан сумын нийгмийн ажилтнуудад амжилттай зохион байгууллаа.	100%

18	Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Жаргалтай гэр бүл” аяныг салбар дундын байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Зорилтот гэр бүлүүдийн гэр бүлдээ хүлээх үүрэг хариуцлага нэмэгдэж, гэр бүлийн эерэг уур амьсгал бүрдсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн тоо багасна.	2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн салбар дундын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан “Жаргалтай гэр бүл” аянд 40 өрхийг амжилттай хамруулж, аяны хугацаанд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх, бага насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах, секц дугуйланд хамруулах зэрэг үйлчилгээ үзүүлэн, 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдөр үр дүнг тайлагнаж, хаалтын үйл ажиллагааг зохион байгууллаа. Мөн тус аянд идэвхитэй оролцсон гэр бүлүүдийг шагнаж урамшуулан, зарим хүүхдийг “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд үнэ төлбөргүй амрах эрхийн бичгээр шагналаа.	100%
19	Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулж, хүүхдийг гэмт хэрэг зөрчил, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг салбар дундын байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Хүүхэд холбогдсон гэмт хэргийн гаралт, зөрчил болон хүүхдийн хүчирхийллийн тоо буурсан байна	ГБХЗХГ-ын даргын А/10 тоот тушаалаар аймгийн хүүхдийн хууль зүйн хороог байгуулж, салбар дундын байгууллагуудтай хамтран үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна.	100%

20	Аймгийн хүүхдийн зөвлөлийг шинэчлэн байгуулах	Аймгийн хүүхдийн зөвлөлийг шинэчлэн зохион байгуулж, үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон байна.	Аймгийн хүүхдийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулахаар засаг даргын захирамжийн төсөл боловсруулан бэлтгээд байна.	90%
21	“Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих”, “Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих” аймгийн дэд хөтөлбөрүүдийг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	“Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих”, “Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих” чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна.	“Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих”, “Залуучуудын хөгжил оролцоог дэмжих” аймгийн дэд хөтөлбөрүүдийг батлуулахаар төсөл хэлбэрээр бэлтгээд байна.	80%
Хүүхдийн паркт хийгдэх үйл ажиллагаа				
22	Хүүхдэд чиглэсэн 1 арга хэмжээг хүүхдийн паркийн нэрэмжит болгон зохион байгуулж, шагнал урамшууллыг ивээн тэтгэж ажиллах	Хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн байна.	2017 оны 01 сарын 27-нд “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театраас зохион байгуулсан бүжгийн уралдаанд 2-р байр эзэлсэн 2-р цэцэрлэгийн нэг бүлгийг 5-р сарын аль нэг өдрийг сонгон, хүүхдийн паркт үнэ төлбөргүй үйлчлүүлж, тоглох эрхээр шагнасан.	100%

23	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хүүхдийн паркийн 2017 оны орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулан, орлогын төлөвлөгөөг биелүүлэх	Хүүхдийн паркийн 2017 оны орлогын төлөвлөгөө батлагдсан байна.	Хүүхдийн паркийн 2017 оны орлого, зарлагын төлөвлөгөөг ГБХЗХГ-ын даргаар батлуулж, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд анхааран ажиллаж байна.	100%
24	ГБХЗХГ-ын ажилтнуудын дунд спорт хамтлагаас зохион явуулах үйл ажиллагаанд хүүхдийн паркийн ажилчдыг идэвхитэй оролцуулах	Ажилтнуудын эрүүл мэндийн байдалд анхааран ажилласан байна.	ГБХЗХГ-аас зохион байгуулсан мөсний баярт хүүхдийн паркийн хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ идэвхи санаачлагатай оролцсон.	100%
Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр				
25	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, архив, албан хэргийн ажилтныг мэргэшүүлэх сургалтанд хамруулах	Байгууллагын архив, бичиг хэргийн ажилтныг албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтанд хамруулж, чадваржуулсан байна.	2017 оны 01 дүгээр сарын 02-ноос 01 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал Улаанбаатар хотод Архивын ерөнхий газарт ГБХЗХГ-ын архив бичгийн хэргийн ажилтан А.Далайжаргал архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалтанд хамрагдсан.	100%
26	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх	Байгууллагын архивын баримтын 40-өөс доошгүй хувь цахим хэлбэрт шилжсэн байна.	Төрийн албаны “Able” программыг ашиглан, ирсэн явсан баримт бичиг болон албан бичгүүдийг цаг тухайд нь программд шивж байршуулж байна.	100%

	үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын архивын баримтын 40-өөс доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж мэдээллийн сан бүрдүүлэх			
Залуучуудад чиглэгдсэн үйл ажиллагаа				
27	Орон нутагт ажиллаж амьдарч байгаа 15-34 насны залуучуудын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	14-35 насны залуучуудын суурь судалгаа, мэдээллийн сантай болсон байна.	Аймгийн 15-34 насны залуучуудын нэгдсэн суурь судалгааг гаргахаар ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд сумдын засаг дарга нарт болон Сайнцагаан сумын багийн засаг дарга нарт албан бичиг хүргүүлэхээр бэлтгээд байна.	80%
28	“Залуу малчдаа дэмжих” аяныг салбар дундын байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Залуу малчдыг дэмжих, нийгмийн амьдралд оролцоход дэмжлэг үзүүлсэн байх, 1 малчин залуу өрхийг малжуулсан байна.	2017 оны 02 дугаар сарын 12-ны өдөр УИХ-ын гишүүн Д.Гантулга, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж нарын бүрэлдэхүүнтэй баг Дундговь аймагт ажиллаж, “Залуу малчдаа дэмжих” аяны хүрээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад “Амжилтын гараа” сэдэвт лекцийг уншиж, мөн “Монголын морин спорт залуу уяачдын холбоо”-ны Дундговь аймаг дахь салбар зөвлөлийг байгууллаа.	100%
29	15-34 насны залуучуудын дунд волейболын тэмцээн зохион байгуулах	-Аймгийн хэмжээний залуучуудыг хамруулсан тэмцээнийг амжилттай зохион байгуулсан байна.	Олон улсын эмэгтэчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан 2017 оны 03 дугаар сарын 16-ны Сайнцагаан	100%

		-Залуучуудын хамтран ажиллах, харилцан туршлага солилцох боломж нээгдэнэ.	сумын 15-34 насны залуучуудын дунд волейболын тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд эрэгтэй 1-р байранд нарлаг 7-р баг, 2-р байранд айраг 8-р баг, 3-р байранд мандал 9-р баг, эмэгтэй 1-р байранд нарлаг 7-р баг, 2-р байранд равжих 5-р баг, 3-р байранд мандал 9-р баг тус тус шалгарч, Сайнцагааны 7-р багийн тамирчид багаараа шилжин явах цомын эзэд боллоо.	
“Бүрдийн уянга” хүүхдийн зусланд хийгдэх үйл ажиллагаа				
30	“Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн кадастрын зураг авахуулах	“Бүрдийн уянга” зуслангийн газар ГБХЗХГ-ын өмчид шилжинэ	“Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн кадастрын зураг авахуулах бэлтгэл ажлыг ханган, 4-р сарын эхний 7 хоногт зургийг авахуулахаар төлөвлөсөн.	90%
31	“Бүрдийн уянга” зусланд амрах амрагчдын ээлжийн хуваарь гаргаж батлуулах	“Бүрдийн уянга” зуслангийн үйл ажиллагааг сайжруулан, амрагчдыг тав тухтай амрах нөхцөлийг бүрдүүлнэ	“Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн 2017 оны ээлжийн хуваарь, хөтөлбөрийг гарган, 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдөр ГБХЗХГ-ын даргаар батлуулан, зуслангийн ээлжийн хуваарь, хөтөлбөрийг хятад, орос, англи 3 хэлээр орчуулж, АЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхээр бэлтгээд байна.	100%

Тайлан бичсэн:

Ахлах мэргэжилтэн Ц.Энхбилгүүн

Хянасан:

Даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Ганзориг